



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“МОН-ИТ БУЛИГААР” ХК

(МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ)

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР
БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АГУУЛГА

	Хуудас
БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ	1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ	2
2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	3
АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	4
АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	5
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7-18

“МОН-ИТ БУЛИГААР” ХК

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

ЗАХИРАЛ: Б.АНХБОЛД
НЯГТЛАН БОДОГЧ : Х.ЛХАГВАСҮРЭН
БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТР : 2039184
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ: Арьс шир боловсруулалт, худалдаа, гадаад худалдаа

БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: (+976- 9911 0026)
Утас: (+976- 9964 2255)

И-мэйл хаяг: buligaar1934.@gmail.com

АУДИТЫН КОМПАНИ:

Нягтлан бодох бүртгэл хяналтын
итгэмжлэгдсэн байгууллага-
УЛИАСТАЙ ВАН АУДИТ ХХК
Утас: 7015 7405, 9911 8571
И-мэйл хаяг: ulistaivanaudit@ubaudit.mn
Вэб хаяг: www.ubaudit.mn
Пэйж хуудас: <https://www.facebook.com/ulistaivan>



“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, бүртгэлийн программ, сургалтын итгэмжлэгдсэн байгууллага

Хаяг : Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Canon төв 602 тоот

Утас : 99118571, 99097405, 70157405

Вeб хуудас: www.ubaudit.mn

Имэйл : ulistaivanaudit@ubaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

20 22 оны 03 сарын 01 № 95/22

**“МОН-ИТ БУЛИГААР” ХК-ийн
УДИРДЛАГАД**

Бид “Мон-ит булигаар” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

“Мон-ит булигаар” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцоололыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцэж байна

[Handwritten signature]
“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

УЛИАСТАЙ
ВАН-АУДИТ ХХК
Page: 02

"МОН-ИТ БУЛИГААР" ХК
 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(мянган төгрөг)

		<u>2020.12.31</u>	<u>2021.12.31</u>
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	4	25,878	18,700
Дансны авлага	5	1,326,475	1,524,809
Татвар, НДШ-ийн авлага	6	302,056	312,003
Бусад авлага	7	797	81,350
Бараа материал	8	4,282,102	6,154,304
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	9	196,785	504,208
Үндсэн хөрөнгө	10	9,980,499	9,623,631
Биет бус хөрөнгө	11	1,496,852	1,328,377
Дуусаагүй барилга	12	-	397,694
Нийт хөрөнгийн дүн		<u>17,611,443</u>	<u>19,945,075</u>
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	13	4,168,487	5,625,611
Цалингийн өглөг		-	1,142
Татварын өглөг	13	420,438	928,853
НДШ-ийн өглөг	13	142,396	216,056
Урьдчилж орсон орлого	13	50,000	-
Богино хугацаат зээл	13	2,187,557	2,144,211
Бусад богино хугацаат өр төлбөр	13	535,400	535,400
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<u>7,504,277</u>	<u>9,451,274</u>
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	14	3,619,591	3,619,591
Урт хугацаат өр төлбөрийн дүн		<u>3,619,591</u>	<u>3,619,591</u>
Өр төлбөрийн нийт дүн		<u>11,123,868</u>	<u>13,070,864</u>
Эзэмшигчдийн өмч			
Өмч / хувцаат/	15	40,021	40,021
Эздийн өмчийн бусад хэсэг	16	266,001	266,001
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16	4,939,092	4,939,092
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	16	1,242,461	1,629,096
Эзэмшигчдийн өмчийн дүн		<u>6,487,576</u>	<u>6,874,211</u>
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн		<u>17,611,443</u>	<u>19,945,075</u>


"МОН-ИТ БУЛИГААР" ХК
 АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

		(мянган төгрөг)	
		<u>2020.12.31</u>	<u>2021.12.31</u>
Борлуулалтын орлого	17	2,965,139	5,298,742
Борлуулалтын өртөг	18	3,429,779	3,432,169
Нийт ашиг, (алдагдал)		<u>(464,641)</u>	<u>1,866,573</u>
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого		-	-
Бусад орлого	19	47,579	326,596
Борлуулалт маркетингийн зардал	20	-	2,272
Ерөнхий ба удирдлагын зардал	21	1,016,493	1,726,304
Санхүүгийн зардал	19	-	400
Бусад зардал	19	-	23,776
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	19	-	(8,182)
Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал		<u>(1,433,555)</u>	<u>432,236</u>
Орлогын албан татварын зардал	22	4,758	45,601
Татварын дараах ашиг, алдагдал		<u>(1,438,313)</u>	<u>386,635</u>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		<u>(1,438,313)</u>	<u>386,635</u>
Цэвэр ашиг (алдагдал)		<u>(1,438,313)</u>	<u>386,635</u>

"МОН-ИТ БУЛИГААР" ХК
 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

(мянган төгрөг)

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн дүн
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	40,021	-	4,939,092	266,001	1,242,461	6,487,576
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						
Залруулсан үлдэгдэл	40,021	-	4,939,092	266,001	1,242,461	6,487,576
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Тайлангийн үеийн цэвэр ашиг (алдагдал)						
Хуваарилсан ногдол ашиг						
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг						
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	40,021	-	4,939,092	266,001	1,242,461	6,487,576
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						
Залруулсан үлдэгдэл	40,021	-	4,939,092	266,001	1,242,461	6,487,576
Бусад дэлгэрэнгүй орлого						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						
Зарласан ногдол ашиг					386,635	386,635
Дахин үнэлгээний нэмэгдлийн						
Өмчид гарсан өөрчлөлт						
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	40,021	-	4,939,092	266,001	1,629,097	6,874,211



"МОН-ИТ БУЛИГААР" ХК

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	(мянган төгрөг)	
	<u>2020.12.31</u>	<u>2021.12.31</u>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн</u>	<u>2,700,350</u>	<u>4,976,297</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,407,132	4,062,232
Бусад орлого	293,218	914,065
<u>Мөнгөн зарлагын дүн</u>	<u>2,056,428</u>	<u>4,985,190</u>
Ажилчдад төлсөн	616,413	635,559
НД-ийн байгууллагад төлсөн	10,000	69,000
Бараа материал худалдан авахад төлсөн	718,992	3,417,282
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	378,861	5,097
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэд төлсөн	49,114	21,440
Хүүний төлбөрт төлсөн	155,812	686,183
Татварын байгууллагад төлсөн	16,269	79,382
Даатгалын төлбөрт төлсөн	200	90
Бусад мөнгөн зарлага	110,769	71,157
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>643,921</u>	<u>(8,893)</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн</u>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад	-	-
<u>Мөнгөн зарлагын дүн</u>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>Мөнгөн орлогын дүн</u>	<u>12,610</u>	<u>7,900</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,160	9,000
Төрөл бүрийн хандив	(5,550)	(1,100)
Бусад	-	-
<u>Мөнгөн зарлагын дүн</u>	<u>658,832</u>	<u>6,186</u>
Зээл, өрийн үнэт цаас төлбөрт төлсөн мөнгө	658,832	6,186
Бусад	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>(646,222)</u>	<u>1,714</u>
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(2,301)</u>	<u>(7,179)</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>28,178</u>	<u>25,878</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>25,878</u>	<u>18,700</u>

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Мон-ит булигаар” ХК нь Монгол Улсын “Компанийн тухай” хууль болон бусад холбогдох хуулийн дагуу 1996 оны 03-р сарын 27-ний өдөр Арьс шир боловсруулалт, худалдаа, гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан.

Тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн тоо өнөөдрийн байдлаар 764 байна.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол Улсын үндэсний валют төгрөг юм. Хавсаргасан санхүүгийн тайланг нэгжийн оронг төгрөгөөр бэлтгэсэн.

Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.


Нягтлан бодох бүртгэлийн суурь

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

Санхүүгийн тайланг бэлтгэх төсөөлөл

Компани одоо болон алсын ирээдүйд үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө нь компанийн касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банк дахь харилцах данснаас бүрдэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютаар хийгддэг мөнгөн хөрөнгийн зүйлсийн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг.

Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монголбанкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэл хийж, ханшийн өөрчлөлтийн улмаас гарсан зөрүүг ханшийн тэгшитгэлийн олз гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз байна.

Валютын солилцоо, арилжааны явцад үүсэн ханшийн зөрүүг валютын арилжааны олз, гарзаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит олз ба гарз байна.

Бусад авлага, урьдчилж төлсөн тооцоо

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, татвар шимтгэлийн авлагыг бусад авлага, урьдчилж төлсөн тооцоонд бүртгэдэг.

Эдгээр авлага, тооцоог нөхөлтийн өртөг буюу төлсөн мөнгөний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

Бараа материал

Бараа материалыг өртөг зах зээлийн үнийн аль багаар нь санхүүгийн тайланд тусгадаг. Өртөг нь бараа материалыг худалдан авахтай холбогдсон зардлаас бүрддэг. Бараа материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлаганана.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүний олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

“МОН-ИТ БУЛИГААР” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж, дансны үнэ, балансын өдрөөрхи бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийнэ.

Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохдоо зах зээлийн өнөөгийн үнэ үнээр тодорхойлно. Мэргэжлийн үнэлгээчид уг үнийг тогтооно.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэж байвал үнэлгээний нэмэгдлийг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Харин дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ цэнэ буурч байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн заалтанд нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа нь дараахь байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	Ашиглагдах хугацаа /жилээр/
Тавилга эд хогшил	10
Компьютер	3
Тээврийн хэрэгсэл	10
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож, бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүйц, компанийн хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүйц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.


Дансны өглөг

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдсон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зардлыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

Бусад өглөг

Компанийн ажилчидтай цалин, тэтгэвэр болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуй нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.



“МОН-ИТ БУЛИГААР” ХК
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, өөрөө явагч хэрэгслийн албан татвар болон бусад татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаанд төлөх бусад байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг бүртгэдэг.

Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг нь өмнөх ба тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр үр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

Үйл ажиллагааны зардал

Компанийн удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг. Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь Збүртгэдэг.


Болзошгүй өр төлбөр

Болзошгүй өр төлбөр нь компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд гарах боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь компанийн бүрэн хяналтанд ороогүй, зөвхөн ирээдүйд нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдол, эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг барагдуулахын тулд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийг гадагш шилжүүлэх шаардлагатай гэсэн магадлалтай биш, уг үүрэг хариуцлагыг төлөх төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй бол балансад хүлээн зөвшөөрдөггүй.

Компанийн орлогын албан татвар

Компанийн санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг Монгол Улсын “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тодорхойлж тайлагнадаг.



“МОН-ИТ БУЛИГААР” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга

Тус хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртлэх татвар ногдуулах жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

Хувь хүний орлогын албан татвар

Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулиар байгууллага ажиллагсдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт төлөх үүрэг хүлээдэг.

Энэ жилийн хувьд хоёр болон гуравдугаар улиралд цалингаас суутган тооцох 10 хувийг Засгийн газраас шилжүүлэх болсонтой холбогдуулан цалингийн бичилтэнд нилээдгүй өөрчлөлт орсон.

Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу байгууллага ажиллагсдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

Энэ жилийн хувьд Ковидтой холбоотойгоор Засгийн газраас нилээдгүй гэнэтийн шийдвэрүүд гарч нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Эхний улирал буюу 1-3 сарын хугацаанд цалингаас суутган тооцох ЭМНДШ-ийн тооцоолол хуулийн дагуу буюу даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар
- Хоёр, гурав дугаар улиралд ЭМД-ийн шимтгэлийн 2 хувиар даатгуулагчаас, ажил олгогчоос 2 хувиар
- Дөрөвдүгээр улирал буюу сүүлийн улиралд ЭМД-ийн шимтгэл 2 хувиар, НД-ийн шимтгэл 5 хувиар, ажиол олгогчоос ЭМД, НДШ-ийн 7 хувиар тус тус тооцон төсөвт төлөх үүрэг хүлээсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), ноогдох бараа үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож, НӨАТ төлдөг.



“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

4. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Ангилал	2020.12.31		2021.12.31
Касс дах бэлэн мөнгө	1,772,130.93		3,296,668.95
Банкин дахь харилцах	24,156,140.43		15,402,920.38
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	25,878,271.36		18,699,589.33

5. ДАНСНЫ АВЛАГА

Ангилал	2020.12.31		2021.12.31
Дансны авлага	1,326,474,533.16		1,524,809,179.35
Дүн	1,326,474,533.16		1,524,809,179.35

6. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

Ангилал	2020.12.31		2021.12.31
НӨАТ-ын авлага	302,055,816.01		312,003,114.73
Дүн	302,055,816.01		312,003,114.73

7. БУСАД БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА

Ангилал	2020.12.31		2021.12.31
Бусад богино хугацаат авлага	797,289.24		81,349,968.20
Дүн	797,289.24		81,349,968.20

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

8. БАРАА МАТЕРИАЛ

Ангилал	2020.12.31	2021.12.31
Түүхий эд материал	615,241,151.69	494,619,788.28
Дуусаагүй үйлдвэрлэл	1,819,527,726.78	3,748,450,203.60
Бэлэн бүтээгдэхүүн	338,565,125.40	198,712,505.28
Бараа материал	1,374,872,649.40	1,599,709,060.20
Хангамжийн материал	133,895,012.86	112,812,496.41
Дүн	4,282,101,666.13	6,154,304,053.77

9. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Ангилал	2020.12.31	2021.12.31
Урьдчилж төлсөн зардал	196,784,516.99	504,208,160.70
Дүн	196,784,516.99	504,208,160.70

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

10. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Хөрөнгийн ангилал	Барилга байгууламж	Машин, тоног техөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт
а. Анхны өртөг							
Эхний үлдэгдэл	17,321,075,450.11	3,362,233,718.27	18,270,550.00	30,184,825.01	8,979,309.09	770,559,027.96	21,511,302,880.44
Нэмэгдсэн	15,409,090.91	188,714,957.10	-	-	9,180,545.46	-	213,304,593.47
Хасагдсан	-	-	-	-	8,181,545.46	-	8,181,545.46
Эцсийн үлдэгдэл	17,336,484,541.02	3,550,948,675.37	18,270,550.00	30,184,825.01	9,978,309.09	770,559,027.96	21,716,425,928.45
б. Хуримтлагдсан элэгдэл							
Эхний үлдэгдэл	9,468,033,872.78	1,629,362,138.55	113,376,055.45	3,058,553.54	4,178,538.43	414,794,922.95	11,530,804,081.70
Нэмэгдсэн	205,389,587.81	277,473,533.36	1,825,947.76	3,050,196.83	2,990,449.70	71,261,447.70	561,991,163.16
Хасагдсан	-	-	-	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	9,673,423,460.59	1,906,835,671.91	13,202,003.21	6,108,750.37	7,168,988.13	486,056,370.65	12,092,795,244.86
в. Үлдэгдэл өртөг							
Эхний үлдэгдэл	7,853,041,577.33	1,732,871,579.72	6,894,494.55	27,126,271.47	4,800,770.66	355,764,105.01	9,980,498,798.74
Эцсийн үлдэгдэл	7,663,061,080.43	1,644,113,003.46	5,068,546.79	24,076,074.64	2,809,320.96	284,502,657.31	9,623,630,683.59

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)


11. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Хөрөнгийн ангилал	Компьютерийн програм хангамж	Бусад биет бус хөрөнгө	Нийт
а. Анхны өртөг			
Эхний үлдэгдэл	6,947,488.59	1,655,8020,500.00	1,662,749,988.59
Нэмэгдсэн	-	-	-
Хасагдсан	-	-	-
Эцсийн үлдэгдэл	6,947,488.59	1,655,8020,500.00	1,662,749,988.59
б. Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	-	165,897,540.42	165,897,540.42
Нэмэгдсэн	3,031,666.67	165,444,268.45	168,475,935.12
Хасагдсан	-		
Эцсийн үлдэгдэл	3,031,666.67	331,341,808.87	334,373,475.54
в. Үлдэгдэл өртөг			
Эхний үлдэгдэл	6,947,488.59	1,489,904,959.58	1,496,852,448.17
Эцсийн үлдэгдэл	3,915,821.92	1,324,460,691.13	1,328,376,513.05

12. БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Ангилал	2020.12.31	2021.12.31
Дуусаагүй барилга	-	397,693,943.36
Дүн	-	397,693,943.36

Санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.



“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

13. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Ангилал	2020.12.31	2021.12.31
Дансны өглөг	4,168,486,514.39	5,625,611,202.02
Цалингийн өглөг	-	1,142,406.11
ААНОАТ-ын өр	4,759,363.72	50,360,577.11
НӨАТ-ын өр	300,923,956.47	760,400,178.01
ХХОАТ-ын өр	84,723,803.74	88,061,566.72
Бусад татварын өр	30,030,868.30	30,030,868.30
НДШ-ын өглөг	142,395,766.52	216,055,867.29
Богино хугацаат зээл	2,187,556,788.00	2,144,211,064.00
Хүүний өглөг	535,400,018.19	535,400,018.19
Урьдчилж орсон орлого	50,000,000.00	-
Дүн	7,504,277,079.33	9,451,273,747.75

14. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Ангилал	2020.12.31	2021.12.31
Урт хугацаат зээл	3,619,590,508.00	3,619,590,508.00
Дүн	3,619,590,508.00	3,619,590,508.00

15. ХУВЬЦААТ КАПИТАЛ

Компанийн хувьцаат капитал нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар **40,021,200.00** төгрөгний энгийн хувьцаанаас бүрдэж байна.

	Хувьцаа эзэмших %	2020.12.31	2021.12.31
Энгийн хувьцаа	100%	40,021,200.00	40,021,200.00
Дүн	100%	40,021,200.00	40,021,200.00

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

16. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ /ХУВЬЦААНААС БУСАД/

Ангилал	2020.12.31	2021.12.31
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,939,092,300.00	4,939,092,300.00
Эздийн өмчийн бусад хэсэг	266,001,000.00	266,001,000.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,242,461,252.55	1,629,096,450.33
Дүн	6,447,554,552.55	6,834,189,750.33

17. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Ангилал	2020.12.31	2021.12.31
Борлуулалтын орлого	2,95,138,608.05	5,298,742,188.05
Дүн	2,95,138,608.05	5,298,742,188.05

18. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Ангилал	2020.12.31	2021.12.31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,429,779,173.55	3,432,168,868.19
Дүн	3,429,779,173.55	3,432,168,868.19

19. БУСАД ОЛЗ, ГАРЗ

Ангилал	2020.12.31	2021.12.31
Бусад орлого	47,578,669.63	326,596,377.75
Санхүүгийн зардал	-	(400,000.00)
Бусад зардал	-	(23,775,722.71)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(8,181,545.46)
Дүн	47,578,669.63	294,239,109.58

Санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК

“МОН-ИТ БУЛИГААР” ХК
 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
 болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга
 (төгрөг)

20. БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

Ангилал	2020.12.31		2021.12.31
Ашиглалтын зардал	-		2,271,900.00
Дүн	-		2,271,900.00


21. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Ангилал	2020.12.31		2021.12.31
Цалингийн зардал	228,177,400.00		774,653,600.00
ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	90,145,300.00		-
Томилолтын зардал	642,600.00		-
Бичиг хэргийн зардал	13,670,900.00		-
Шуудан холбооны зардал	4,678,600.00		-
Мэргэжлийн үйлчилгээний зардал	9,880,200.00		-
Ашиглалтын зардал	72,152,700.00		951,650,452.54
Элэгдэл хорогдлын зардал	450,796,300.00		-
Харуул хамгаалалтын зардал	27,451,000.00		-
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	5,315,200.00		-
Шатахууны зардал	9,744,600.00		-
Зар сурталчилгааны зардал	21,984,500.00		-
Албан татварын зардал	16,077,400.00		-
Хангамжийн зардал	8,053,300.00		-
Бусад зардал	57,723,200.00		-
Дүн	1,016,493,200.00		1,726,304,052.54

22. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Ангилал	2020.12.31		2021.12.31
Орлогын татварын зардал	4,757,866.97		45,601,213.39
Дүн	4,757,866.97		45,601,213.39

Санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.



“Улиастай ван аудит” ХХК



“МОН-ИТ БУЛИГААР” ХК

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар
болсон

Санхүүгийн тайлангийн аудит

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Захирал:
П.Ганцолмон
Утас: 7015 7405, 9911 8571


Аудитор
Д.Рэгзэдмаа
Утас : 7015-7405

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1: Бараа материалын үлдэгдлийн талаар

“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК

Хэвлэсэн огноо :
2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр



Менежментийн захидал

Аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг хоршооны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитийн олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийгддэг аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Мон-ит Булигаар” ХК-ны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Бараа материалын үлдэгдлийн талаар

Ажиглалт

Тус байгууллагын нягтлан бодогчийн боловсруулсан санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл нь 709,212 мянган төгрөгөөр тооллогын бүртгэлээс дутуу илэрхийлэгдсэн зөрчил илэрсэн улмаар Барааны өртөгийг илүү тооцоолж бүртгэлд тусгасан.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим
Хэвлэх

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:

5.1.1. бие даасан байх;

5.1.2. тасралтгүй байх;

5.1.3. жинхэнэ хэрэгжилтийн;

5.1.4. үнэн зөв байх;

5.1.5. хэмжигдэхүйц байх;

5.1.6. зохицох.

14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

14.4.1. аж ахуйн бүх ажил, гүйлгээ;

14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

14.4.3. бүх өр төлбөр;

14.4.4. аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр;

14.4.5. бүх орлого;

14.4.6. бүх зардал;

Бараа материалын үлдэгдлийг 6,154,304 мянган төгрөг мөн ББӨ-ийг 3,432,169 мянган төгрөгөөр бүртгэлд тусгах

Эрсдэлүүд

Хөрөнгийн үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган шалгаагүй байдлаас үүдэн санхүүгийн тайлан улмаар бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл зөрөх эрсдэлтэй.

